

## “ТЕГЕРАН-43”- ХАМТЫН ХҮЧЭЭР ЭНХИЙГ ТОГТООХЫН ЖИШЭЭ БОЛОХ НЬ

*К.Дэмбэрэл\**

Хэдийгээр хүн төрөлхтний түүх нь дайн байлдаан, үхэл хагацал, эвдрэл сүйрлээр арвин ч үүнийг даван туулах чадвар, тойрон өнгөрөх арга ухааныг эрдэнэт хүмүүн оюун ухаандаа нэгэнт үрслүүлжээ. Ингэхийн зайлшгүйг ч түүх баттай нотолж байна. Олон улсын харилцааны онолчид үүнийг янз бүрээр тайлбарладаг хэдий ч хүн төрөлхтөн чухамхүү юуг эрхэмлэдгийг түүх дэнсэлсээр байна.

Дэлхийн II дайны гал ид дүрэлзэж байх үед АНУ, ЗХУ, Их Британий дээд удирдлагууд Ираны нийслэл Тегеранд 1943 оны 11 сарын 28-наас 12-р сарын 1-ний хооронд уулзалдан хүн төрөлхтний түүхэнд цар хүрээгээрээ зүйрлэшгүй байсан энэ дайныг хэрхэн түргэн дуусган энхийг тогтоох асуудлаар ярилцаж чухал зөвшилцөлд хүрснийг нь түүхэнд “Тегераний бага хурал” хэмээн нэрлэгдэн үлдсэн билээ.

Энэхүү бага хурал нь хамтын хүчээр энхийг хангах гэсэн “том бүтээл” гэдэг утгаар нь энэ өгүүллээр уг хурлын 60 жилийн ой давцгаж буй түүхэн үед судлаачийн байр сууриа илэрхийлэхийг хүслээ.

АНУ-ыг төлөөлж ерөнхийлөгч Ф.Д.Рузвельт, түүний хамт Г.Хопкинс, адмирал Леги, адмирал Кинг болон генерал Маршалл, Арнольд нарын цэргийн дээд офицерууд, ЗХУ-ыг төлөөлж маршал И.Сталин, түүнтэй цуг В.Молотов, маршал Ворошилов бусад офицеруудын хамтаар, Их Британийг төлөөлж ерөнхий сайд У.Черчилль, түүний хамт А.Иден, Дилл нар болон тэдний жанжин штабынхан оролцжээ. Хурлын үеэр болж байсан хүлээн авалт, оройн хоолны байдлаас үзэхэд 3 талаас нийт 40 гаруй хүн оролцсон бололтой.

Колоний эзэнт улс болсон Их Британи, Оросын эзэнт улсын орыг дэрлэн боссон коммунист Зөвлөлт улс, тухайн үед дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 50 шахам хувийг дангаараа үйлдвэрлэж глобал хэмжээний их гүрний статусыг олчихоод байсан АНУ нь энэхүү бага хуралд өөр өөрсдийн сонирхлоо түлхүү тавин оролцсон хэдий ч тухайн улсын удирдагчдын ухаалаг байр суурь тэднийг нэгдмэл хүчээр энхийг тогтоох алхмыг хийхэд хүргэсэн.

АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельт тэргүүтэй төлөөлөгчид тодорхой шалтгааны улмаас Зөвлөлтийн Элчин сайдын яамны байранд

\*К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

байрлах болсноор “Их гурвын” удирдагчдын аюулгүй байдлын асуудал шийдэгдэхийн хамт ЗХУ-ын ЭСЯ нь бага хурлын үеэр “дэлхийн улс төрийн төв” болон хувирсан. Зөвхөн У.Черчилль л хуралдаанд өөрийн ЭСЯ-ны байрнаас явж оролцож байсан хэдий ч байрлал нь ойрхон тул түүнд тийм ч хүндрэлтэй байсангүй.

### **1943 оны 11 сарын 28-ны хуралдаан буюу анхны өргөтгөсөн хурал**

Хурал үдээс хойш 16 цагт эхэлж, эхний хуралдааныг ерөнхийлөгч Рузвельт даргалсан. Тэрээр хурлыг нээж, оролцогчдод баяр хүргэн хэлэхдээ: “анх удаа оросууд, америкчууд, англичууд ялалтад хүрэх ганц зорилго өвөртлөн нэг ширээний ард нэг гэр бүлийн гишүүд мэт суусгааж байна”.<sup>1</sup> Ер нь хурал урьдчилсан төлөвлөсөн хуваарийн дагуу бус харин ихээхэн нээлттэй, оролцогчид хэлэх гэсэн санаагаа ил, тод чөлөөтэй илэрхийлж байсан нь талууд өөр хоорондоо тодорхой хэмжээгээр итгэж байсных биз. Ерөнхий сайд У.Черчилль хэлэхдээ: “энэ зөвлөгөөн нь хүн төрөлхтний түүхэнд урьд байгаагүй дэлхийн их хүчний төвлөрөл болж байна. Биднээс дайны ялалтыг түргэтгэх, хүн төрөлхтний хувь заяа, аз жаргалын асуудлууд шалтгаална”.<sup>2</sup> И.Сталин хэлэхдээ: “Бидэнд үнэхээр том боломж олдож байна. Энэ боломжийг бүрэн дүүрэн ашиглан гэдэгтээ ихээхэн найдвар тавьж байна”.<sup>3</sup>

Төрийн тэргүүн нар өөр өөрсдийн орны өмнө тулгарч буй асуудлыг дэлгэн тавихын зэрэгцээ цаашид хэрхэх тухайгаа саналын хэмжээнд гаргаж тавьжээ. Хурлын гол зорилго бол II фронт буюу “Оверлорд” ажиллагааг хэдийд хэрхэн эхлүүлэхийг тогтох явдал байв. Тиймээс энэ операцийг явуулахтай шууд буюу шууд бус холбоотой асуудлыг хөндөн ярилцсан. Тэдгээрийн дотор Итали, Балкан, Эгийн тэнгис, Туркт байлдааны ажиллагаа хэрхэн явуулах, тухайлбал алинд нь илүү ач холбогдол өгөх зэргийг шийдэх асуудал орж байлаа. Америк-английн армийн гол зорилт бол Зөвлөлтийн ачааллыг болох хэмжээгээр хөнгөлөхөд оршиж байсан.

Ф.Рузвельт Номхон далай дахь байлдааны явцын талаар мэдээлээд, Европын дайны талбарт II фронт нээх асуудлыг ямар чиглэлд хийвэл ЗХУ-д ашигтай вэ гэдэгт Сталины саналыг сонсох бодолтойгоо ч хэлсэн. АНУ нь Японыг цохих тэмцэлд Хятадыг түшиц газраа болгох, ер нь Хятадыг дайнд идэвхтэй татан оролцуулаад дайны дараах “энхийн хуралд” суулгах зорилгыг баримталсан.

И.Сталины зорилго бол “Оверлорд”-ыг яг хэзээ эхлэх вэ гэдгийг л бодиттой мэдэж авах явдал байлаа. Ер нь ЗХУ ганцаардмал байдал орчихоод байсан. Алс Дорнодын асуудлаар тэрээр хэлэхдээ: “Бид тэнд хангалттай хүчээр батлан хамгаалж байгаа. Хэрвээ бид тэнд давшилтанд орох тохиолдолд хүчээ 3 дахин нэмэх хэрэгтэй. Харин Германыг дарсны дараа хамтын хүчээр оролцоход татгалзах зүйлгүй”. Зөвлөлт-германы фронтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийсэн ба “Оверлорд”-ыг хаагуур хэдийд явуулах нь түүнд ашигтай тухайд ч саналаа илэрхийлсэн.

У.Черчиллийн хувьд дайны дараа Европт хүчний тэнцвэрийг хадгалах явдал гол нь байлаа. Ингэхийн тулд хаагуур хэнтэй, хэрхэн эвсэж дайныг явуулах, Европын улс төрийн картын ирээдүйн дүр зургийн ерөнхий тоймыг тодорхойлж авах нь чухал байв. Энэ хурлын үеэр У.Черчилль өөрийгөө томоохон стратегич гэдгээ батлан харуулсан. Гурван удирдагчийн санал ойрын хэдэн арван жил Германыг хяналтандаа байлгах тухайд ч нийлж байсан. У.Черчилль бүр ойрын 50 жил хэмээн тодотгож байсан удаатай.

Дайны дараах Европын шинэ дэгийн асуудалд нэлээдгүй хугацааг хурлын үеэр зарцуулсан нь ажиглагдаж байгаа. Тухайлбал, Польшийг ямар дүр төрхтэй, хаагуур хилийн шугамыг нь “татаж өгөх”, Европт ямар үүрэгтэй улс байлгах, ямар засаглалтай гэх мэтээр маш нухацтай авч хэлэлцсэн. Учир нь Америкт 6 сая польш үндэстэн сонгуульд оролцдог нь Рузвельтэд нэн хамаатай, Польшийн төлөө дайнд орсон Их Британид Польшийн асуудал бүхнээс чухал, баруун талдаа томоохон буфер улстай байх нь И.Сталинд юунаас ч чухал байв. Эх сурвалжаас үзэхэд Балканы асуудал, Туркийн байр суурь ч их гүрнүүдийн оролцоогүйгээр шийдэгдэхгүй зүйлийн нэг гэдэг нь хурлын үед ажиглагдаж байна. Хурлын үеэр Германыг яаж хуваах вэ гэдэг дээр талууд “харандаа, цаас” барин орох тохиолдолд ч гарч байв.

### **1943 оны 11 сарын 29-ний өргөтгөсөн хурал**

29-ний өглөө гурван талын жанжин штабынхан хамтарсан хурлаа явуулж “Оверлорд” операцийн талаар өргөтгөсөн хуралд оруулах материалуудыг бэлтгэсэн. Хурлын эхэнд У.Черчилль эзэн хааныхаа “Хүндэт илд”-ийг Сталинградын баатарлаг тулалдааны хүндэтгэл болгож И.Сталинд гардуулсан нь 2 дахь өдрийн хуралдааныг илүү дулаан уур амьсгалтай болгожээ. Цэргийнхэн зохих төлөвлөгөөг танилцуулсны дараа удирдагчид бие биендээ асуулт тавьж зохих

хариултыг сонсчээ. “Оверлорд”-ыг яг хэдийд эхлэх вэ гэсэн Сталины асуултад хурлын дараа ойрын үед шийднэ гэж байснаа хурал дуусахаас өмнө шийдэх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн бөгөөд түүнийг хэн удирдах вэ гэсэн Сталины дараагийн асуулт энэ өдрийн хуралдааны “нэлээд цагийг барав” хэмээн Черчилль өөрийн тэмдэглэлдээ бичсэн. “Их гурвын удирдагчид” бие биенийхээ санал, зөвлөмжийг маш талархалтайгаар хүлээн авч байсан нь хурлын бас нэг онцлог юм. Мөн энэ өдрийн хуралдаанд “Оверлорд”-той холбоотой туслах ач холбогдол бүхий операцуудын талаар тогтож ярилцаад зохих зөвшилцөлд хүрсэн. Энэ өдрийн оройн зоогийг Сталин барьсан бөгөөд чухам энэ үед Сталин, Черчилль нарын үзэл санаа, бодлогын “унаган” зөрчил илэрсэн хэдий ч наргиа маягаар өнгөрүүлсэн. Учир нь ярианы явцад Сталин “Гитлерийн Германы жанжин штабыг түүний цөм болсон 50000 цэргийн албан хаагчдын хамтаар хүйс тэмтрэх хэрэгтэй”<sup>4</sup> хэмээн хэлжээ. Гэтэл Черчилль босч, “Английн парламент, олон нийт энэхүү “нядалгааг” үл тэвчнэ. Зөвлөлтийн төлөөлөгчид тийм төөрөгдөлд орохгүй байх ёстой”<sup>5</sup> хэмээн хэлсэн. Гэтэл Сталин түүгээр зогсолгүй цааш үргэлжлүүлэн “50000-ууланг нь буудах ёстой” гэхэд Черчилль тэсч үл чадан “эх орныхоо нэр төрийг тэгж харлуулахын оронд өөрийг буудчихвал дээр” хэмээн нэлээд бухимдсан байдалтай өгүүлэхэд, байдал эвгүй болж буйг мэдэрсэн Рузвельт яриаг наргиа руу шилжүүлэх санаатай “50000-ыг бус 49000-ыг буудах ёстой” гэж шоглох маягаар өгүүлэв. Гэтэл Эллиот Рузвельт босч хувьдаа Сталиныг дэмжиж буйгаа хэлээд америкийн арми ч дэмжинэ хэмээн “дарин дээр давс” гээч болоход Черчилль тэсэлгүй өөрөөнөөс гарчээ. Хэсэг хугацааны дараа Сталин, Молотов нар түүн дээр ирж “ердөө л тоглоом байсан шүү дээ” хэмээн яриагаа цайруулж түүнийг тайтгаруулсан. Хурлын үеэр “их гурвын удирдагчид” өөрсдийн бодлогоо гаргаж тавихдаа янз бүрийн арга, хэлбэрээр яриаг үргэлжлүүлж байжээ гэсэн бодол дээрх жишээнээс харагдаж байна.

### **1943 оны 11 сарын 30-ны өдрийн хуралдаан**

Энэ өдөр Их Британий ерөнхий сайд У.Черчиллийн төрсөн өдөр давхцсан байсан тул өдрийн хуралдааны дараа тэрээр хуралдагсдыг ЭСЯ-ндаа оройн зоогт урьсан. Зөвлөлтийн тусгай албад яамны байрыг нарийвчлан шалгаснаас өөр сүртэй зүйлгүйгээр цайллага эвсэг орчинд болсон. Рузвельтийн хувьд Черчилльтэй уулзах уулзалтаас бага хурлын

үед аль болох татгалзаж байсан. Учир нь Сталинд ямар нэг сөрөг сэтгэгдэл төрүүлэхгүй байх нь түүнд юу юунаас чухал байсан.

Тегераны хурлын өмнө Каирт Рузвельт, Черчилль нар уулзсан хэдий ч “Оверлорд” операцийн талаар тодорхой асуудлыг шийдээгүй. Учир нь тэр уулзалтад Хятадын Чан Кайши оролцсон тул хятадын асуудлыг ярьсаар байгаад бараг цаг олдоогүй аж. Черчилль, Сталин нарын энэ өдрийн ганцаарчилсан уулзалтаар “Оверлорд”-ыг нэлээд тууштай хэлэлцээд ямар ч байсан операцийг 1944 онд эхэлнэ, харин хугацааг Рузвельтийн оролцоогүйгээр хэлэх боломжгүйг тайлбарлахад Сталин сэтгэл ихэд хангалуун байсан. Учир нь Их Британ “Оверлорд”-ыг тасалдуулаад Балкан руу яваад орчихож магадгүй гэсэн болгоомжлол Сталинд байсан хэмээн улс төр судлаачид үздэг. Харин тэр өдрийн үдийн зоог дээр Рузвельт “Оверлорд”-ыг 5-р сард эхэлнэ хэмээн бид урьд нь тохирсон гэдгээ Сталинд хэлэхэд тэрээр урьдынхаас илүү тайвширсан, сэтгэл хангалуун байдал түүнд ажиглагдсан гэж Черчилль дурдатгалдаа тэмдэглэжээ. Энэ үеэр Черчилль гурван талд хамтын хүчээр Дорнод, Өрнөд, Газар Дундын тэнгисийн гурван фронтод нягт хамтарсан нэгдмэл зорилготой үйл ажиллагааг явуулахын чухлыг тэмдэглэсэн байдаг. Чухам энэ өдөр л 1944 оны 5-р сард “Оверлорд” операци эхлэх нь тодорхой болсон юм.

### **1944 оны 12 сарын 1 өдрийн буюу төгсгөлийн хуралдаан**

Энэ өдөр урьд хэлэлцсэн Европын аюулгүй байдлын асуудал өөрөөр хэлбэл хүчний тэнцвэрийн асуудал, Германыг хэрхэн хэсэглэн хуваах, Польшийн асуудал, Туркийг дайнд татан оруулах, Финландын асуудал болон ерөнхий хил хязгаарын тухайд тогтож ярилцсан. Хуралдаан урьдынхыг бодвол илүү “ширүүн” уур амьсгалд явагдсан. Гол нь Европын хил хязгаарын асуудал байснаас тэр биз дээ.

Тегераны бага хурлын явцад яригдсан гол асуудлын нэг бол дайны дараах дэлхийн шинэ дэг, аюулгүй байдлыг хэрхэн хангах асуудал байлаа. Ялангуяа 11 сарын 29-нд энэ асуудлаар нэлээд дэлгэрэнгүй ярилцаж талууд дараах саналыг дэвшүүлжээ.

АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельт “дэлхийн асуудлыг” АНУ, Их Британ, ЗХУ, Хятад гэсэн “дөрвөн цагдаагаар” хянуулж байх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлсэн нь И.Сталины хувьд хүлээж авах боломжгүй зүйл байлаа. Учир нь Европын асуудлыг зохицуулахад Хятад оролцоно гэдэг нь европчуудын хувьд санаанд нь оромгүй зүйл, мөн дайны дараа гэхэд Хятад тийм хэмжээний хүчтэй улс болж чадна гэдэг нь эргэлзээтэй байв.

И. Сталины хувьд “дэлхийн асуудлыг” зохицуулахад Европт нэг, Алс Дорнодод нэг хороог тус тус байгуулах нь зүйтэй байлаа. Европын хороог АНУ, Их Британ, ЗХУ + 1 европын улс гэссэн схемээр байгуулах саналыг дэвшүүлсэн. Энэ санал нь урьд Рузвельт (хурлаас өмнө) Европ, Алс Дорнод, Америкийн хороодоор дамжуулан “шинэ дэгийг” тогтоох боломжтой гэсэнтэй нэлээд дүйж байсан. Энэ үеэр У.Черчилль нэгдсэн үндэстний дэлхийн зөвлөлийг байгуулах түүнд 3 бүсийн хороог оруулах санааг цухуйлгав. НҮБ-ын үр хөврөлийн асуудал уг хурлаар ийм хэмжээнд яригдаад зогссон юм. Гэвч энэ нь цаашдын дэлхийн шинэ дэгийн асуудалд чухал ач холбогдолтой болсон билээ.

Хурлын үеэр удирдагчдын хооронд зарим асуудлаар үл ойлголцох зүйл гарч байсан хэдий ч асуудал тухай бүрнээ шийдэгдэж байлаа. Энэ талаар Сталин хэлэхдээ: “Үл ойлголцлоос эхлэлтэй нөхөрлөл хамгийн сайн нь байдаг шүү дээ” хэмээн Черчилльтэй гар барьсан хэмээн тэмдэглэгдэн үлджээ. Черчиллийн хувьд Их Британий сонирхолд ямар нэг хэмжээгээр харшилсан зүйл хийвэл дор нь огцрох боломжтой мөн аливаа асуудлын мөн чанарыг бусдад хэлж, ухуулж ойлгуулах нь түүний байр сууриа хадгалах ганц боломж байсан бол Рузвельт, Сталин нарын хувьд тушаалаар бүхнийг шийдэх боломжтой байсан зэргээр парламентийн болон ерөнхийлөгчийн эсвэл тоталитар засаглалын гол ялгаа хуралдааны үйл ажиллагааны тэмдэглэлээс илт мэдрэгдэж байна.

### ИШЛЭЛ

1. У.Черчилль. Вторая мировая война. Ростов-на-Дону., 1997, 367 т.
2. мөн гэнд, 368 т.
3. мөн гэнд.
4. Г.Киссенжер. Дипломатия. М., 1997. 369 т.
5. мөн гэнд.